



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/183

Булган сум

**Залуучуудын сайн дурын ажлын  
өдрүүдтэй болох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дах заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/130 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг дэмжин урамшуулах зорилгоор улирал бүрийн сүүлийн сарын сүүлийн долоо хоногийг “Залуучуудын сайн дурын өдрүүд” болгон зарласугай.

2.“Залуучуудын сайн дурын өдрүүд”-ээр залуучуудаас гарсан санал санаачилгыг дэмжиж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Т.Баярбат)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ